

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019-09-05

Тендерийн дугаар: МРЦМ/201906692

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших Цээлийн булгийн усны эх үүсвэрийн талбайд газрын доорхи усны ашиглалтын хайгуул хийх хүрээнд гидрогеологийн судалгаа, усны хайгуул хийлгэх, гүний цооног өрөмдүүлэх, гүний худгийн байгууламж байгуулах үйлчилгээг хийлгэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа “Бор-Өндөр” УБҮ-ийн ажилчид, Бор-Өндөр хотын оршин суугчдын ундны усны эх үүсвэрийн талбайд газрын доорх усны ашиглалтын хайгуул хийх, худгийн байгууламж байгуулах зэрэг ажил, үйлчилгээг хийлгэх болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга,
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/,
- Тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/,
- Сүүлийн 3 жил ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар,
- НӨАТ төлөгчийн гэрчилгээ

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 17:00 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгээ **Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем** [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар 2019 оны 09 дүгээр сарын 13-ны дотор ирүүлнэ үү.

**Монгол Улс, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, өөрийн байр**  
**Утас: 458401, Факс: 458380 Имэйл хаяг: [mailbox@monros.mn](mailto:mailbox@monros.mn)**  
**Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар**  
**ирүүлнэ.**